



Хүн бүрд хүний эрх, шударга ёс, нэр төр

БЭЛГИЙН БОЛОН ХҮЙСИЙН ЦӨӨНХ ОЛОН НИЙТИЙН ТУХАЙ АСУУГДДАГ ТҮГЭЭМЭЛ АСУУЛТУУД





Энэхүү гарын авлагын энэ удаагийн хэвлэлийг Америкийн ард түмний дэмжлэгээс бүрдсэн АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн санхүүгийн дэмжлэгтэйгээр Азийн сангийн хэрэгжүүлж буй "Монгол Улсад хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн салбарыг бэхжүүлэх нь" хөтөлбөрийн хүрээнд шинэчлэн хэвлэв. Тус бүтээлд илэрхийлэгдсэн агуулга нь зохиогчийн үзэл санаа бөгөөд АНУ-ын засгийн газар эсвэл дээрх агентлаг, сан, байгууллагуудын албан ёсны байр суурь биш болно.

“ЛГБТИК+” нэр томъёоны тайлбар: Лесбиян, гей, бисексуал, трансжендэр, интерсекс, күйир болон бусад гэсэн үгсийн товчлол. ЛГБТИК+ хэмээх үг нь бүх бэлгийн болон хүйсийн цөөнхийг бүрэн төлөөлөх утгаараа зөв хэрэглээ болдог.

● АГУУЛГА

- Бэлгийн чиг баримжаа гэж юу вэ? Хүйсийн баримжаа, илэрхийлэл гэж юу вэ?
- ЛГБТИК+ гэж ямар үгсийн товчлол вэ? Бэлгийн чиг баримжаа төрөлхийн үү, олдмол уу? Хэзээ илэрдэг вэ?
- Хүйсийн баримжаа төрөлхийн үү, олдмол уу? Хэзээ илэрдэг вэ?
- Бэлгийн чиг баримжаа болон бэлгийн зан үйлийн хооронд ялгаа бий юу?
- ЛГБТИК+ хүмүүст хандах хандлага Монгол улсад ямар байгаа вэ?
- ЛГБТИК+ хүмүүсийн эрхийг ханган хамгаалахын тулд юу шаардлагатай байгаа вэ?
- Монгол улсын Засгийн газраас ЛГБТИК+ хүмүүсийн эрхийг хамгаалахын тулд юу хийж байна вэ?
- Монголд хэдэн ЛГБТИК+ хүн байдаг вэ?

- Сүүлийн үед ЛГБТИК+ хүмүүс ихсээд байгаа юм биш үү?
- ЛГБТИК+ хүний эрхийг сурталчилснаар хүмүүсийг уруу татах юм биш үү?
- Чимээгүй байж болдоггүй юм уу?
- ЛГБТИК+ хүмүүсийн эрхийг хуулиар баталгаажуулсан улс орнууд хэд байдаг вэ? Яаж хамгаалсан байдаг юм бол?
- ХДХВ/ДОХ нь гей залуучуудын өвчин гэх юм, хэр үнэн бэ?
- “Тэгш эрх, бахархлын өдрүүд” үйл ажиллагаа яагаад хэрэгтэй вэ?
- ЛГБТИК+ хүмүүсийн тэмдэглэдэг олон улсын тэмдэглэлт өдрүүд юу юу байдаг вэ?
- ЛГБТ Төв ТББ-ын алсан хараа, хөтөлбөрүүд, ажлуудын тухай
- ЛГБТ Төв ТББ-д хүмүүс хэр их ханддаг вэ?

БЭЛГИЙН ЧИГ БАРИМЖАА ГЭЖ ЮУ ВЭ?

Бэлгийн чиг баримжаа нь:

- эсрэг хүйсийн (**стрэйт**)
- ижил хүйсийн (**эрэгтэйчүүдийг гей, эмэгтэйчүүдийг лесбиян**)
- аль ч хүйсийн хүмүүст (**бисексуал**)

бие махбод, хайр дурлал, зүрх сэтгэлийн хувьд татагдах төрөлхийн, өөрчлөгдөшгүй хүний мөн чанар юм.

Бэлгийн чиг баримжаа нь биологийн үндэстэй буюу төрөлхийн, эпигенетик гэдэг нь батлагдсан.

ХҮЙСИЙН БАРИМЖАА ГЭЖ ЮУ ВЭ?

Хүйсийн баримжаа нь хүн бүр хувь хүнийхээ үүднээс өөрийн бие махбод, хүйсээ төрөхөд тэмдэглэгдсэн хүйстэйгээ

- ижлээр (**сизжендэр эрэгтэй, сизжендэр эмэгтэй**)
- өөрөөр эсвэл эсрэгээр (**транс* эрэгтэй, транс* эмэгтэй, нонбайнари гэх мэт**)

гүн гүнзгий төрөлхийн, өөрчлөгдөшгүй хүний мөн чанар юм.

Нонбайнари - өөрийгөө эрэгтэй, эмэгтэй гэх аль ч хүйст багтааж үздэггүй, эсвэл аль аль хүйст хамааруулж мэдэрдэг хүмүүсийн хувьд хэрэглэдэг олон улсын нэр томьёо.

ХҮЙСИЙН ИЛЭРХИЙЛЭЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Хүний хүйсийн баримжааны гадаад илэрхийлэл. Энэ илэрхийлэл нь хүн биеэ авч явахдаа ихэвчлэн эмэгтэйлэг, эрэгтэйлэг эсвэл хүйсийг нь тодорхойлох боломжгүй байдлаар илэрхийлж буй байдлууд болох хувцаслалт, үс засалт, хоолой болон бие махбодын шинж тэмдгээр илэрдэг.

Хүйсийн илэрхийлэл тухайн нийгэм, соёлоос хамаарч ямар ч байж болох бөгөөд хүйсийн илэрхийлэл нь хүний бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжааг шууд илтгэнэ гэсэн үг биш гэдгийг анхаарах хэрэгтэй.

Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийлэл нь хоорондоо холбоотой ойлголт уу?

Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийлэл нь өөр хоорондоо хамааралгүй буюу нэг нэгээсээ ялгаатай ойлголт юм. Эмэгтэйлэг хувцасласан хүн бүр транс* хүн эсвэл гей хүн байна гэсэн үг биш. Трансжендэр эрэгтэй хүн бүр стрэйт буюу эмэгтэй хүнд татагддаг гэж таамаглах боломжгүйг анхаарна уу. Учир нь сизжендэр хүмүүс бэлгийн чиг баримжааны хувьд өөр хоорондоо ялгаатай байдаг шиг трансжендэр хүмүүс ч мөн өөр өөр бэлгийн чиг баримжаатай байх боломжтой. ЛГБТИК+ гэдэг нь бэлгийн болон хүйсийн цөөнх хүмүүсийг хэлэх олон улсын хэвшмэл нэр томьёоны товчлол юм.

ЛГБТИК+ ГЭЖ ЯМАР ҮГСНИЙН ТОВЧЛОЛ ВЭ?

- ☑ **Лесбиян** - ижил хүйсийн бэлгийн чиг баримжаатай эмэгтэйчүүд
- ☑ **Гей** - ижил хүйсийн бэлгийн чиг баримжаатай эрэгтэй хүмүүс (ижил хүйсийн бэлгийн чиг баримжаатай хүмүүсийг нийтэд нь мөн гей гэж хэлэх тохиолдол байдаг)
- ☑ **Бисексуал** - аль аль хүйсийн, аль эсвэл нэгээс олон хүйст татагддаг бэлгийн чиг баримжаатай хүмүүс
- ☑ **Транс*** - өөрийн хүйсийг төрөхөд тэмдэглэгдсэн хүйсээсээ өөрөөр эсвэл эсрэгээр тодорхойлдог хүмүүс
- ☑ **Интерсекс** - хүйсийн анхдагч болон хоёрдогч бэлгийн шинж чанар буюу ген, гормон, анатомийн олон шалтгаанаас үүдэн хүний биологийн хүйс эр, эм аль нь болох нь тодорхойгүй байж болдог. Хромосом, гонад болон бэлгэ эрхтний хувьд эр, эм аль хүйст хамаарахыг нь шууд хэлэх боломжгүй хүмүүс. Биологийн бие махбодын олон янзат байдлыг тодорхойлоход хэрэглэдэг ерөнхий нэр томьёо

☑ **Күйр** - бэлгийн чиг баримжаа болоод хүйсийн баримжаа, илэрхийллийн хувьд цөөнх хүмүүсийг нийтэд нь ЛГБТИК+ эсвэл күйр гэдэг. Түүхийн хувьд КҮИЙР гэдэг үг нь анх доромж утгаар хэрэглэгддэг байсан ч цаг хугацааны явцад ЛГБТИК+ хүмүүс энэ үгийг өөрийгөө бахархалтайгаар илэрхийлэх үг болгож чадсан юм. Энэ нэр томъёог бэлгийн чиг баримжаа болон хүйсийн баримжааг хоёр туйлт гэж үздэггүй аль эсвэл өөрийгөө тодорхойлохыг хүсэхгүй байгаа бэлгийн болон хүйсийн цөөнх хүмүүс хэрэглэдэг. Хэдий тийм ч бүх ЛГБТИК+ хүмүүс энэ үгийг өөртөө хамаатуулан ашигладаггүй.

☑ **"+"** тэмдэг нь энэ нэр томъёонуудад хязгаарлагдахгүй бусад нэр томъёонуудыг (асексуал, жендэркүйр, нонбайнари, пансексуал гэх мэт) ашигладаг олон нийтийг хамруулж байгаагийн илэрхийлэл юм. Мөн өөрийн бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжааг хүмүүст хэлээгүй, нуугдмал амьдардаг олон нийт болон ЛГБТИК+ олон нийтийн ялгаатай байдлыг буюу үндэсний цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй бэлгийн болон хүйсийн цөөнх олон нийт байгааг илэрхийлж үргэлжид ЛГБТИК нэр томъёоны араас ашигладаг.

БЭЛГИЙН ЧИГ БАРИМЖАА ТӨРӨЛХИЙН ҮҮ, ОЛДМОЛ УУ? ХЭЗЭЭ ИЛЭРДЭГ ВЭ?

Бэлгийн чиг баримжаа гэдэг нь төрөлхийн, хүн хүндээ татагдах, дурлах хүний мөн чанарыг хэлдэг ойлголт юм. Бэлгийн чиг баримжаа бэлгийн зан үйлээр илэрхийлэгдэж ч болно, үгүй ч байж болно. Бэлгийн чиг баримжаа ихэнхдээ бэлгийн бойжилтын насанд илэрдэг. Гаднын нөлөөнөөс, жишээ нь: хүнд уруу татагдаж, эсвэл шохоорхож, сонирхсон зэргээс болж бэлгийн чиг баримжаа өөрчлөгддөггүй.

1973 онд Америкийн сэтгэл судлалын нийгэмлэгээс ижил хүйсийн бэлгийн чиг баримжааг сэтгэцийн эмгэг биш гэдгийг тогтоосон. Мөн 1990 онд Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-аас ижил хүйсийн бэлгийн чиг баримжааг "Өвчний олон улсын ангилал"-ын жагсаалтаас хассан байдаг.

ХҮЙСИЙН БАРИМЖАА ТӨРӨЛХИЙН ҮҮ, ОЛДМОЛ УУ? ХЭЗЭЭ МЭДЭХ БОЛОМЖТОЙ БЭ?

Хүйсийн баримжаа нь хүн бүрийн өөрийн хүйс, биеэ мэдрэх гүн гүнзгий төрөлхийн, өөрчлөгдөшгүй хүний мөн чанар учир хүүхэд маш бага наснаасаа үүнийгээ мэдэрч, илэрхийлж байдаг. Хүйсийн баримжаа ихэнхдээ хүүхдийн бага насанд илэрдэг ч транс* байдал илрэх тодорхой насыг заах боломжгүй. Хүйсээ төрөхөд тэмдэглэгдсэн хүйстэйгээ ижил хэмээн мэдэрдэг, түүгээрээ нийгэмшдэг хүнийг **сизжендэр** гэдэг бол хүйсээ төрөхөд тэмдэглэгдсэн хүйсээсээ өөрөөр эсвэл эсрэгээр мэдэрдэг, тодорхойлдог, түүгээрээ нийгэмшдэг хүнийг **трансжендэр/транс*** гэдэг.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-аас 2019 оны 5-р сарын 25-нд Өвчний олон улсын ангиллыг шинэчлэх томоохон шийдвэр гаргасан. Энэхүү шинэчилсэн хувилбарт трансжендэр байдлыг "сэтгэцийн эмгэг"-ийн ангилалд багтаахаа больсон юм.

БЭЛГИЙН ЧИГ БАРИМЖАА БОЛОН БЭЛГИЙН ЗАН ҮЙЛИЙН ХООРОНД ЯЛГАА БИЙ ЮУ?

Бэлгийн чиг баримжаа нь хүнд татагдах, дурлах сэтгэл, оюун, бэлгийн салшгүй мөн чанар. Бэлгийн зан үйл нь бэлгийн үйлдэл л төдий. Бэлгийн зан үйл буюу үйлдэл нь бэлгийн чиг баримжаанд суурилсан ч байж болдог, үгүй ч байж болдог. Хүйсээр тусгаарлагдсан нөхцөлд, жишээ нь, сүм хийд, цэргийн хуаран, хорих анги гэх мэт газруудад ижил хүйсийн бэлгийн зан үйл их байдаг ч энэ бол нөхцөл байдлаас үүдсэн бэлгийн зан үйл гэж тооцогддог. Энэ тохиолдолд ижил хүйсийн бэлгийн хавьталд орж буй хүмүүс өөрсдийгөө ЛГБ буюу бэлгийн цөөнх гэж тодорхойлох нь цөөн байдаг.

ЛГБТИК+ ХҮМҮҮСТ ХАНДАХ НИЙГМИЙН ХАНДЛАГА МОНГОЛД ЯМАР БАЙНА?

Нийгэмд бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийллийн тухай, ЛГБТИК+ хүний эрхийг ханган хамгаалах болон хүний эрхийн ойлголт, мэдээлэл дутмаг байгаагаас сөрөг хандлагууд илэрсээр байдаг. Энэхүү сөрөг хандлагаас үүдэн ЛГБТИК+ хүмүүсийн нийгэм, эдийн засаг, соёлын эрх өдөр тутамд зөрчигдсөөр байна.

Хэдий тийм боловч хүний эрх хамгаалагчид эсхүл үнэн зөв мэдлэг мэдээлэл авч, мөн түгээж буй иргэдийн ачаар Монгол дахь хүмүүсийн ЛГБТИК+ олон нийтэд хандах хандлага бага багаар сайжирч байгааг дурдах нь зүй биз ээ.

ЛГБТИК+ ХҮМҮҮСИЙН ЭРХИЙГ ХАНГАН ХАМГААЛАХЫН ТУЛД ЮУ ШААРДЛАГАТАЙ БАЙГАА ВЭ?

Хүний эрх гэдэг нь хоорондоо харилцан хамааралтай, түгээмэл, хуваагдашгүй гэсэн гурван цогц зарчимд суурилдаг. ***Нэг бүлэг хүмүүсийн хүний эрхийг нөгөө бүлэг хүмүүсийн эрхээс дээгүүр эсвэл доогуур авч үзэх ёсгүй.*** Тиймээс Монгол улсын Эрүүгийн хуульд заасан "Ялгаварлан гадуурхах" гэмт хэргийн тухай таниулан сурталчлах, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх замаар иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх нь чухал байна. Хүн бүр ялгаварлан гадуурхагдахаас хамгаалагдсан бөгөөд Үндсэн хуулиар баталгаажсан эрхээ эдлэх бодитой эдлэх эрхтэй билээ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРААС ЛГБТИК+ ХҮМҮҮСИЙН ЭРХИЙГ ХАНГАН ХАМГААЛАХЫН ТУЛД ЮУ ХИЙЖ БАЙНА ВЭ?

Монгол Улсын Засгийн газар ЛГБТИК+ хүний эрхийн нөхцөл байдлыг сайжруулж тэдний эрхийг ханган хамгаалах ёстой талаар НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл болон Гэрээдийн хороодоос өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхээр хүлээн авсан байдаг. Энэ нь МУ-ын Засгийн газар ЛГБТИК+ хүний эрхийг ханган хамгаалах үүргээ Олон улсын өмнө хүлээн зөвшөөрсөн гэсэн үг юм. Хууль, эрх зүйн хувьд 2017 оны 7-р сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Эрүүгийн хуулиар Ялгаварлан гадуурхахыг гэмт хэрэг болгон зүйлчилсэн.

МОНГОЛД ХЭДЭН ЛГБТИК+ ХҮН БАЙДАГ ВЭ? СҮҮЛИЙН ҮЕД ЛГБТИК+ ХҮМҮҮС ИХСЭЭД БАЙГАА ЮМ БИШ ҮҮ?

Бэлгийн болон хүйсийн цөөнх хүмүүс ямар ч орны хүн амын 2-10% гэсэн нийтлэг жишиг тоо байдаг. Нийгэм бүрд өөр өөр тоо гардаг нь тухайн оронд хүний эрхийг хэр хэмжээнд хамгаалсан, ЛГБТИК+ хүмүүс хэр нээлттэй амьдрах боломжтой гэх зэрэг асуудалтай шууд холбоотой. Жишээ нь, 2014 онд Иран улсад хийсэн судалгаагаар насанд хүрсэн хүмүүсийн 18% ижил хүйсийн бэлгийн туршлагатай гэсэн тоо гарсан байдаг. 2000 онд АНУ анх удаа хүн амын тооллогын үеэр бэлгийн чиг баримжааны талаарх асуултыг асуулгадаа багтаасан байдаг ба 2010 онд дахин багтааснаар тооллогын үр дүнд газар зүйн байршил үл хамааран ЛГБТИК+ хүмүүс бүх нийгэм-эдийн засаг, соёл, үндэстний гаралтай байдаг гэдгийг баталгаажуулсан байдаг.

Монгол улсын хувьд сүүлийн үед ЛГБТИК+ хүмүүсийн тоо их болж байгаадаа биш, харин өмнө нь нуугдмал амьдардаг байсан олон нийт хүмүүсийн хандлага болон эрх зүйн орчин бага багаар сайжрахын хэрээр ил амьдрах зоригтой болж, өөрийгөө нээлттэй илэрхийлж эхэлсэнтэй холбоотой юм.

ЛГБТИК+ ХҮНИЙ ЭРХИЙГ СУРТАЛЧИЛСНААР ХҮМҮҮСИЙГ УРУУ ТАТАХ ЮМ БИШ ҮҮ? ЧИМЭЭГҮЙ БАЙЖ БОЛДОГГҮЙ ЮМ УУ?

Хүн болгон өөрийн насанд тохирсон мэдээллийг эрэлхийлэх, хүртэх, дамжуулах, түүнчлэн бусдын эрхэд халдсан бус байдлаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй байдаг нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний болон улс төрийн эрхийн пакт болон бусад Монгол Улсын нэгдэж орсон олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр баталгаажсан. Нийгэмд байсаар байгаа буруу, ташаа ойлголтыг үнэн, бодит мэдээллээр л зүгшрүүлэх учир ЛГБТИК+ эрхийн тухай, ЛГБТИК+ хүмүүсийн өмнө тулгарч буй бэрхшээлүүд болон бодит байдлыг ярих ёстой болдог. Мэдээлэл өгснөөр хүнийг уруу татна гэсэн ойлголт үүсэхгүй, учир нь бэлгийн чиг баримжаа төрөлхийн, өөрчлөгдөшгүй зүйл. Харин мэдээлэлгүй байдлын хор уршиг нь маш олон зүйл дээр илэрдэг. Жишээ нь, ЛГБТИК+ өсвөр насныхан гэр орныхондоо бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаагаа илэрхийллээ гэхэд гэр орныхны зүгээс төрөл бүрийн хүчирхийлэл амсаж байгаа нь нийгэмд бэлгийн цөөнхийн талаар мэдээлэл, ойлголт тун бага байгаатай шууд холбоотой.

ЛГБТИК+ ХҮМҮҮСИЙН ЭРХИЙГ ХУУЛИАР БАТАЛГААЖУУЛСАН УЛС ОРНУУД ХЭД БАЙДАГ ВЭ? ЯАЖ ХАМГААЛСАН БАЙДАГ ЮМ БОЛ?

Дэлхийн улс орнууд бэлгийн чиг баримжаа болон хүйсийн баримжаа, илэрхийллээр ялгаварлан гадуурхахыг хориглосон хууль тогтоомжтой. Үүнд, Европ бүхэлдээ, мөн Латин Америкийн ихэнх орон, Төв ба Хойд Америкийн ихэнх орон болон Африкийн хэд хэдэн орон багтаж байна. Харин Аргентин, Бельги, Бразил, Канад, Дани, Грийнланд, Финлянд, Франц, Исланд, Ирланд, Люксембург, Мексик, Голланд, Шинэ Зеланд, Норвеги, Португал, Словени, Өмнөд Африк, Испани, Швед, Их Британи, АНУ, Уругвай, Тайвань улсуудад ижил хүйсийн гэрлэлтийн хууль хэрэгждэг бол Андorra, Австрали, Австри, Чиле, Колумб, Хорват, Чех, Эквадор, Эстони, Герман, Унгар, Итали, Япон, Лихтенштэйн, Мальта, Швейцарь, Венесуэл улсуудад ижил хүйсийн гэрлэлттэй тэнцэх иргэний гэрлэлтийн зохицуулалт байна. Харамсалтай нь ижил хүйсийн харилцаан зөвшилцлийн үндсэн дээр хийгдсэн бэлгийн зан үйлийг Иран, Судан, Саудын Араб, Мавритани, Сомалид болон Нигерийн зарим хэсэгт цаазаар авах ялаар яллассаар байна.

ХДХВ/ДОХ ГЕЙ ЗАЛУУЧУУДЫН ӨВЧИН ГЭХ ЮМ БИЛЭЭ, ХЭР ҮНЭН БЭ?

1980-аад оны эхээр барууны орнуудад хурдацтайгаар тархаж байх үед гей болон бисексуал залуучуудын дунд нэлээд ажиглагдсан учир тухайн үед “гей хар тахал” гэсэн буруу нэршилтэй байсан ч сүүлдээ ямарваа эрсдэлт бэлгийн зан үйлээс болж ямар ч насны, ямар ч хүйсийн, ямар ч бэлгийн чиг баримжаатай хүмүүст халдаж болох халдвар гэдэг нь тогтоогдсон. Сүүлийн жилүүдийн судалгаагаар хөгжиж буй орнуудад эсрэг хүйсийн бэлгийн чиг баримжаатай эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн дунд нэлээд их тархаж байгаа өвчин. Монголын хувьд гей, бисексуал эрчүүд болон транс* эмэгтэйчүүд байнга сайн дурын зөвлөгөө, шинжилгээнд идэвхтэй хамрагдаж буй утгаараа тэднийг залуучуудын дунд нь илүү тархсан мэт харагдаж байгаа нь үнэн.

"ТЭГШ ЭРХ, БАХАРХЛЫН ӨДРҮҮД" ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯАГААД ХЭРЭГТЭЙ ВЭ?

ЛГБТИК+ гэдгээрээ бахархах нь битгий хэл, дотнын хүмүүс дундаа ч нээлттэй амьдарч буй ЛГБТИК+ хүмүүс цөөхөн хэвээр байсаар байна. Хүн бүрийг эрхээ эдлэх нөхцөл бололцоогоор хангах үүргийг төр хүлээсэн байдаг, үүний зэрэгцээ хүн бүр бусад хүний эрхийг хүндэтгэх үүргийг мөн хүлээдэг. Хүн бүр тэгш эрхтэй гэдгийг бие биедээ ойлгуулах, мөн ЛГБТИК+ хүмүүс Монголын хүн амын түүхэн хэсэг байсаар байсан, байсаар байх болно гэдгийг үнэн зөвөөр харуулах, олон нийтийн хүний эрхийн боловсролыг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагаа чухал.

"ТЭГШ ЭРХ БАХАРХЛЫН ӨДРҮҮД" МОНГОЛД ХЭД ДЭХ УДАА БОЛЖ БАЙНА ВЭ?

Тэгш эрх, бахархлын өдрүүд нь анх 2013 оны 9-р сарын 22-28-ны хооронд "Бахархлын долоо хоног" нэртэйгээр зохион байгуулагдаж байсан. Энэхүү үйл ажиллагаа нь 2014 оноос "Тэгш эрх, Бахархалын өдрүүд" нэртэйгээр зохион байгуулагдаж эхэлсэн. Жил бүрийн 8-р сарын сүүлийн 7 хоногоос 9-р сарын эх хүртэл зохион байгуулагддаг бөгөөд хүний эрхийн дэмжигчид, ЛГБТИК+ олон нийтийн хүсэн хүлээсэн тэмдэглэлт өдрүүд болсоор байгаа.

ЛГБТИК+ ХҮМҮҮСИЙН ТЭМДЭГЛЭДЭГ ОЛОН УЛСЫН ТЭМЛЭГЛЭЛТ ӨДРҮҮД ЮУ ЮУ БАЙДАГ ВЭ?

2 **2-р сарын 14-өөс эхлэх 7 хоног.** Аромантик байдлыг ойлгох 7 хоног.

3 **3-р сарын 01-ний өдөр.** Zero discrimination day / Ялгаварлан гадуурхалтгүй өдөр
3-р сарын 08-ны өдөр. ОУ-ын эмэгтэйчүүдийн эрхийн өдөр
3-р сарын 31-ний өдөр. Транс байдлыг ойлгох олон улсын өдөр

4 **4-р сарын 06-ны өдөр.** Асексуал байдлын талаар мэдлэгээ тэлэх өдөр
4-р сарын 26-ны өдөр. Лесбиян байдлыг ойлгох өдөр

5 **5-р сарын 17-ны өдөр.** АЙДАХОТБ-Олон улсын Гомофоби, Бифоби, Трансфобийн Эсрэг Өдөр
5-р сарын 24-ний өдөр. Пансексуал байдлыг ойлгох өдөр

6 **6-р сар бүхэлдээ.** АНУ, Их Британи, Канад, Франц г.м. улсуудад Бахархлын сар

7 **7-р сарын 14-ний өдөр.** Олон улсын нонбайнари өдөр
7-р сарын 06-ны өдөр. Дрэг өдөр

8 8-р сарын сүүлийн Баасан гарагаас эхлэн Монгол дахь Тэгш эрх, Бахархлын өдрүүд

9 9-р сарын 23-ны өдөр. ОУ-ын Бисексуал байдлыг ойлгох өдөр

10 10 сарын 11-ний өдөр. Камин аут буюу өөрийгөө илэрхийлэх өдөр
10-р сарын 3 дахь 7 хоногийн Лхагва гарагт Төлөөний үгний өдөр
10-р сар бүхэлдээ. АНУ-ын ЛГБТИК+ түүхийн сар
10-р сарын 26-ны өдөр. Интерсекс байдлыг ойлгох өдөр

11 11-р сарын 08-ны өдөр. Интерсекс хүмүүсийн гэгээн дурсгалыг хүндэтгэх өдөр
11-р сарын 20-ны өдөр. Трансжендэр хүмүүсийн гэгээн дурсгалыг хүндэтгэх өдөр

12 12-р сарын 01-ний өдөр. Дэлхийн ДОХ-ын эсрэг өдөр
12-р сарын 10-ны өдөр. ОУ-ын хүний эрхийн өдөр гэх мэт өдрүүд байдаг.

Жич: Энэхүү жагсаалтад ороогүй өдрүүд мөн байгаа болно.

ЛГБТ ТӨВ ТББ-ЫН АЛСЫН ХАРАА ХӨТӨЛБӨРҮҮД, АЖЛУУД

ЛГБТ Төв ТББ-ын алсын хараа, хөтөлбөрүүд, ажлууд ЛГБТ Төв нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага нь 2009 оноос хойш бэлгийн цөөнх болох лесбиян, гей, бисексуал, трансжендэр, интерсекс, күйр болон бусад хүмүүсийн хүний эрхээр дагнан ажиллаж буй Монголын анхны ЛГБТИК+ хүний эрхийн байгууллага юм.

Монгол Улсад хүний эрхийг хүндэтгэх соёлыг үүсгэх, хөхиүлэн дэмжих, ЛГБТИК+ хүмүүс болоод бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийллийн талаар буруу мэдээлэл, ойлголт зонхилсоор байгааг арилгахын тулд олон нийтэд үнэн зөв, бодит мэдээллийг өгөх нь нэн чухал байгаа энэ үед соёл урлагийн хэрэгслээр хүмүүст мэдээлэл хүргэх нь маш чухал. Тиймээс ЛГБТ Төв нь 2014 оноос урлаг соёлын хөхиүлэн дэмжих стратегийн чиглэлтэй болж, жилдээ нэг удаа визуал уран бүтээлчдийн дунд уралдаан, мөн 2013 оноос эхлэн бүх нийтийн хүний эрхийн боловсролыг сайжруулах “Тэгш эрх, бахархлын өдрүүд”-ийг зохион байгуулж эхэлсэн. ЛГБТ Төв нь 2015 оноос эхлэн дотоод бүтэцдээ өөрчлөлт хийн, Эрх зүй, Эрүүл мэнд, Залуучуудын гэсэн хөтөлбөрүүдээр дамжуулан Монгол Улсад бэлгийн цөөнхийн эрхийг ханган хамгаалах асуудал дээр ажиллаж байна.

“ЛГБТ Төв” ТББ 2008 оноос хойш Монгол дахь ЛГБТИК+ хүмүүсийн нөхцөл байдлын талаарх дараах илтгэлүүдийг бэлтгэн явуулсан. Үүнд:

- НҮБ-ын Хүний эрхийн хорооны Хүний эрхийн тогтмол түгээмэл хэлэлцүүлэгт (2010, 2015 онд)
- Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай гэрээний хороонд (2008, 2016 онд)
- Эрүүдэн шүүхийн эсрэг хороонд (2011, 2016 онд)
- Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хороонд (2015 онд)
- Иргэний болон улстөрийн эрхий хороонд (2011, 2016 онд)
- Хүүхдийн эрхийн хороонд (2017 онд)

Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм журамд ЛГБТИК+ хүмүүсийг ялгаварлан гадуурхалтаас хамгаалах зохицуулалтууд:

2017 оны 7-р сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Монгол Улсын Эрүүгийн хуульд:

14.1 дүгээр зүйл. Ялгаварлан гадуурхах

1. Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, эрүүл мэндийн нөхцөл байдлаар ялгаварлан гадуурхаж эрх, эрх чөлөөг нь хязгаарласан бол дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

/Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

2. Энэ гэмт хэргийг:

2.1. бүлэглэж;

2.2. хүч хэрэглэж;

2.3. албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж үйлдсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3. Хүндрүүлэх нөхцөл байдал

Үзэл бодол, арьсны өнгө, үндэс, угсаа, шашин шүтлэг, бэлгийн, хүйсийн чиг баримжаагаар нь үзэн ядаж үйлдсэн нь зарим гэмт хэргийн хувьд хүндрүүлэх нөхцөл болон орсон.

Трансжендэр хүмүүсийн эрхийг хангах зохицуулалт:

Иргэний улсын бүртгэлийн тухай хууль

14 дүгээр зүйл. Хүйс өөрчлөгдсөний бүртгэл

14.1. 18 нас хүрсэн иргэн хүйсээ өөрчилснийг иргэний улсын бүртгэлд бүртгүүлэх бол дараах баримт бичгийг бүрдүүлж, улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад өөрийн биеэр бүртгүүлнэ:

14.1.1. өргөдөл;

14.1.2. иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээ;

14.1.3. эмнэлгийн байгууллагаас хүйс өөрчлөгдсөнийг нотолсон баримт бичиг.

14.2. Энэ хуулийн 14.1-д заасан баримт бичигт дараах баримт бичгийн аль тохирохыг хавсаргана:

14.2.1. гэрлэлт дуусгавар болсон тухай эрх бүхий байгууллагын шийдвэр;

14.2.2. хүүхдийн эцэг /эх/-ийн нэрийн бүртгэлд өөрчлөлт оруулах бол эцэг /эх/-ийн өргөдөл;

14.2.3. хүүхдийн төрсний гэрчилгээ, иргэний үнэмлэх.

14.3. Улсын бүртгэгч энэ хуулийн 14.1, 14.2-т заасан баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын 7 өдрийн дотор хүйс өөрчлөгдсөний бүртгэлийг хөтөлнө.

Мөн түүнчлэн дараах албан хаагчдын ёс зүйн дүрэмд бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийллээр ялгаварлан гадуурхахгүй байх талаар зааж, мөрдөгдөж байна.

Эдгээрт:

- Эмнэлгийн мэргэжилтэн нь үйл ажиллагаандаа шударга ёс, хууль дээдлэх, тэгш байдал, үл ялгаварлан гадуурхах, хариуцлага хүлээх, үйлчлэх зарчмыг баримтална (Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, Эрүүл мэндийн сайдын 2013 оны 11-р сарын 25-ны 446-р тушаалын 1-р хавсралт) Үл ялгаварлан гадуурхах гэж Монгол Улсын Үндсэн хуулийн 14.2-т зааснаас гадна төрх байдал, эрүүл мэндийн байдал, бэлгийн чиг хандлага, хүйсийн баримжаа, хүн амын тодорхой бүлэгт харьяалагдах байдлаар алагчлахгүй байхыг (Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ)
- Иргэдийн эрүүл мэндийн байдал, өвчин эмгэгийн төрөл, оршин суугаа газар, нас, хүйс, боловсрол, бэлгийн чиг хандлага, үндэс угсаа, хэл соёлын ялгаанаас үл хамааран тэгш, хүртээмжтэй хүргэх (Тулгуур зарчим, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний бодлого батлах тухай Эрүүл мэндийн сайдын 2014 оны 2-р сарын 24-ний өдрийн 55-р тушаалын хавсралт)

- Эрүүл мэндийн яам: 2013, 2014 онд салбарын хөгжлийн бодлого болон салбарын мэргэжилтний ёс зүйд ялгаварлан гадуурхалтын эсрэг зарчмыг багтаасан.
- Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм (Монгол Улсын Засгийн Газрын 2010 оны 288 дугаар тогтоолын хавсралт, 5 дугаар зүйлийн 5.2.3-т зааснаар)
- Цагдаагийн албан хаагчийн ёс зүйн дүрэм (Цагдаагийн ерөнхий газрын даргын 2011 оны 598 дугаар тушаалын хавсралт, 4 дүгээр зүйлийн 4.1.2-т зааснаар)
- Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим (Хэвлэл Мэдээллийн Зөвлөлийн Ёс зүйн хороодын 2015 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн нэгдсэн хуралдааны нэгдүгээр тогтоолын хавсралт)
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны ёс зүйн дүрэм (Ерөнхий байдлаар ялгаварлан гадуурхахгүй байх гэж заасан)

ЛГБТ ТӨВ-Д ХҮМҮҮС ХЭР ИХ ХАНДДАГ ВЭ?

Өөрийн болон ах, эгч, дүүгийнхээ бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийллийн тухай илүү ойлголттой болохыг хүсэж буй хүмүүс, мөн бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийллээс үүдэн хүний эрх нь зөрчигдсөн тохиолдолд сэтгэл зүйн болон эрх зүйн туслалцаа авахаар хандах нь маш их.

Түүнчлэн сүүлийн жилүүдэд төрийн болон төрийн бус байгууллагууд, мөн хувийн хэвшлийн байгууллагууд өөрсдийн үйлчлүүлэгчид болон ажилтнуудын ялгаатай байдалд мэдрэмжтэй хандах зорилгоор сургалт авах нь нэмэгдэж байна.

2019 оноос хойш хувь хүмүүсийн хандиваар сайн дурын ажилтнуудын өрөөтэй болж, олон нийтэд илүү нээлттэй болсон юм.

Монгол ЛГБТИК+ хүмүүсийн бодит түүх, тэдний дурсамж, хайр дурлал, нөхөрлөл гэх зэргийн тухай сонсохыг хүсвэл манай «Mongolian Queer Podcast»-аас хүлээж авна уу. Дараах сувгуудаас хайлт хийн сонсоорой:

- Soundcloud.com
- Youtube.com
- Castbox.fm
- Apple podcast
- Mplus.mn

“ЛГБТ Төв” ТББ-тай холбогдох:

Утас: 70110323

Цахим шуудан: info@lgbtcentre.mn

Фейсбүүк: The LGBT Centre (Mongolia)

Инстаграм: [@lgbtcentre.mongolia](https://www.instagram.com/lgbtcentre.mongolia)

Твиттер: [@LGBTMongolia](https://twitter.com/LGBTMongolia)

Youtube: [LGBT Centre Mongolia](https://www.youtube.com/LGBT%20Centre%20Mongolia)

Веб хаяг: www.lgbtcentre.mn